



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/11/НА-СТА-ТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Мандалговь хот  
2022 он

Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан  
Утас: 70593113  
Цахим хаяг: [batsaikhant@audit.gov.mn](mailto:batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Oyunerdenet@audit.gov.mn](mailto:Oyunerdenet@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

|                                                                           |    |
|---------------------------------------------------------------------------|----|
| 1.Товчилсон үгийн жагсаалт.....                                           | 2  |
| 2. Аудитын санал дүгнэлт.....                                             | 3  |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....                  | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....                           | 5  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                        | 5  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....             | 6  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                            | 6  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                         | 7  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                  | 8  |
| 3. Аудитын тайлан.....                                                    | 8  |
| 3.1 Ерөнхий зүйл.....                                                     | 8  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....                       | 8  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                            | 9  |
| 3.4 Материаллаг байдал.....                                               | 9  |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....                                  | 10 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                       | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....                  | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал.....                                              | 13 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 14 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....                           | 14 |
| 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....                                | 14 |
| 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....              | 14 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                             | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт.....                                                 | 15 |
| 4.1 Залруулсан алдаа.....                                                 | 16 |
| 4.2 Албан шаардлага.....                                                  | 16 |
| 4.3 Зөвлөмж.....                                                          | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....                          | 17 |

## 1.Товчилсон үгийн жагсаалт

---

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                                   |
| ХШҮДАХ   | Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс             |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                                 |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал                                |
| ХХК      | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                        |
| БСШУЯ    | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам                         |
| ЕБС      | Ерөнхий боловсролын сургууль                                |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                                   |
| ТТЗ      | Төсвийн төвлөрүүлэн захирагч                                |
| ЭМТ      | Эрүүл мэндийн төв                                           |

---



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сүм  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.24. № 79

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-  
УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ө.МӨНХ-АМГАЛАН ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020892

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код:  | Тайлангийн үзүүлэлт                                                   | Тодруулга      | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|-------|-----------------------------------------------------------------------|----------------|-----------------------|------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                                               |                | 654,594.8             | 857,172.8              |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ                                                        | 3а, 3б         | 257,717.7             | 379,043.0              |
| 33    | АВЛАГА                                                                | 5а, 5б, 6а, 6б | 212,964.5             | 211,204.7              |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ                                                        | 8а, 8б, 8в     | 183,912.5             | 266,925.1              |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                                           |                | 2,765,459.4           | 3,483,783.1            |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                                        | 12а, 12б, 12в  | 2,765,459.4           | 3,483,783.1            |
| 39200 | Биет хөрөнгө                                                          |                | 2,706,872.9           | 3,399,168.4            |
| 39300 | Биет бус хөрөнгө                                                      | 13             | 58,586.5              | 84,614.7               |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                                           |                | 3,420,054.1           | 4,340,955.9            |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР                                                        |                | 31,558.0              | 49,529.0               |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                             | 15а, 15б       | 31,558.0              | 49,529.0               |
| 41300 | Өглөг                                                                 | 17а, 17б       | 31,558.0              | 49,529.0               |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                                              |                | 3,388,496.1           | 4,291,426.8            |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо                                           |                | 3,388,496.1           | 4,291,426.8            |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |                | 1,119,548.2           | 1,459,192.7            |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                                                  |                | 967,027.6             | 1,443,192.0            |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      |                | 1,301,920.3           | 1,389,042.2            |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           |                | 3,420,054.1           | 4,340,955.9            |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | Тодруулга | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|----------------------------------------------------------|-----------|-----------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          |           | 2,526,214.8           | 2,976,472.8            |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                          |           | 50,778.4              | 107,095.2              |
| 110  | Орлогын албан татвар                                     |           | 29,179.7              | 26,207.9               |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          |           | 29,179.7              | 26,207.9               |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   |           | 1,936.0               | 1,824.0                |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            |           | 19,662.7              | 79,063.3               |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 1а, 1б    | 336,510.1             | 696,227.4              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              |           | 336,510.1             | 696,227.4              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            |           | 2,138,926.3           | 2,173,150.2            |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 2а, 2б    | 2,242,112.6           | 2,538,767.6            |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            |           | 2,242,112.6           | 2,538,767.6            |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          |           | 1,431,702.8           | 2,422,372.7            |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        |           | 800,374.6             | 1,192,168.2            |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           |           | 99,045.7              | 153,680.2              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                |           | 167,484.5             | 191,157.4              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         |           | 66,097.8              | 140,294.1              |
| 2105 | Нормативт зардал                                         |           | 24,123.6              | 265,218.7              |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        |           | 43,475.3              | 28,375.4               |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   |           | 10,285.4              | 9,298.7                |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |           | 17,371.1              | 12,352.6               |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          |           | 203,444.8             | 429,827.3              |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         |           | 810,409.7             | 116,394.9              |

**Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|     |                                                 |  |           |           |
|-----|-------------------------------------------------|--|-----------|-----------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)           |  | 284,102.3 | 437,705.1 |
| V   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                 |  | 88,152.7  | 9,970.0   |
| VI  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) |  | 195,949.5 | 427,735.1 |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт                        | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|--------------------------------------------|----------------------------------------|-----------------------|------------------------|
| 1    | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 3,188,103.1                            | 0                     | 3,188,103.1            |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,443.5                                | 0                     | 4,443.5                |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 3,192,546.6                            | 0                     | 3,192,546.6            |
| 9    | Тайлант үеийн үр дүн                       | 195,949.5                              | 0                     | 195,949.5              |
| 10   | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 3,388,496.1                            | 0                     | 3,388,496.1            |
| 11   | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл        | 3,388,496.1                            | 0                     | 3,388,496.1            |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -29,810.3                              | 0                     | -29,810.3              |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 3,358,685.8                            | 0                     | 3,358,685.8            |
| 17   | Өмчид гарсан өөрчлөлт                      | 505,005.9                              | 0                     | 505,005.9              |
| 19   | Тайлант үеийн үр дүн                       | 427,735.1                              | 0                     | 427,735.1              |
| 20   | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл      | 4,291,426.8                            | 0                     | 4,291,426.8            |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|----------------------------------------------------------|------------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                   | 2,289,634.9            | 2,324,811.6            |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                          | 50,778.4               | 107,095.2              |
| 110  | Орлогын албан татвар                                     | 29,179.7               | 26,207.9               |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          | 29,179.7               | 26,207.9               |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   | 1,936.0                | 1,824.0                |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 19,662.7               | 79,063.3               |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж                            | 3,678.7                | 5,768.4                |
| 1181 | Газрын төлбөр                                            | 15,984.1               | 18,690.1               |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр                          | 0.0                    | 54,604.8               |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 99,930.1               | 136,535.2              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 99,930.1               | 136,535.2              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 2,138,926.3            | 2,081,181.2            |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 2,107,986.3            | 2,027,612.8            |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 2,107,986.3            | 2,027,612.8            |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 1,297,576.6            | 1,910,597.8            |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 800,374.6              | 1,192,118.2            |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 99,045.7               | 153,680.2              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 167,484.5              | 192,085.5              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 43,843.7               | 64,102.9               |
| 2105 | Нормативт зардал                                         | 25,230.6               | 123,949.4              |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 77,792.3               | 55,237.8               |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 10,285.4               | 9,298.7                |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,695.4               | 13,777.6               |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 52,824.4               | 106,347.4              |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 810,409.6              | 117,014.9              |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | 181,648.6              | 297,198.8              |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                | 118,416.6              | 175,873.5              |



**Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|      |                                                        |            |            |
|------|--------------------------------------------------------|------------|------------|
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                       | 118,416.6  | 175,873.5  |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                    | 118,416.6  | 175,873.5  |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)  | -118,416.6 | -175,873.5 |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -69,000.0  | 0.0        |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ             | 69,000.0   | 0.0        |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)      | -5,768.0   | 121,325.3  |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл       | 263,485.7  | 257,717.7  |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл      | 257,717.7  | 379,043.0  |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код    | Үзүүлэлт                                                 | Төлөвлөгөө  | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|--------|----------------------------------------------------------|-------------|-----------------------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 2,326,558.6 | 1,980,554.5                 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 1,983,838.5 | 1,877,097.9                 |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 1,933,970.6 | 1,829,385.2                 |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,203,603.2 | 1,183,900.8                 |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 163,153.1   | 152,579.9                   |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 194,567.4   | 192,085.5                   |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                         | 54,825.3    | 53,778.2                    |
| 2105   | Нормативт зардал                                         | 63,257.4    | 59,450.4                    |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 135,025.4   | 115,641.2                   |
| 2107   | Томилолт, зочны зардал                                   | 11,807.7    | 9,213.0                     |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,009.1     | 5,824.7                     |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 101,722.0   | 56,911.5                    |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 49,867.9    | 47,712.7                    |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                   | 49,867.9    | 47,712.7                    |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                         | 195,138.7   | 103,456.6                   |
| 23     | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 147,581.4   | -                           |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 2,326,558.6 | 2,055,180.8                 |
| 31     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 1,308,588.3 | 1,294,144.6                 |
| 32     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 689,145.4   | 668,307.0                   |
| 33     | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ             | 36,228.9    | 17,310.8                    |
| 35     | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                    | 292,596.0   | 75,418.5                    |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -           | 217,578.7                   |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -           | 304,223.0                   |
| 6      | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                         | 530         | 467                         |
| 61     | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                         | 6           | 6                           |
| 610001 | Төсвийн байгууллага                                      | 6           | 6                           |
| 62     | АЖИЛЛАГСДЫН ТОО                                          | 108         | 104                         |
| 620001 | Удирдах ажилтан                                          | 12          | 12                          |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                                        | 65          | 55                          |
| 620003 | Үйлчлэх ажилтан                                          | 29          | 35                          |
| 620004 | Гэрээт ажилтан                                           | 2           | 2                           |
| 63     | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)                       | 308         | 253                         |
| 630    | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД                            | 189         | 178                         |



**Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|        | СУРАЛЦАГЧИД                                                   |     |     |
|--------|---------------------------------------------------------------|-----|-----|
| 630001 | Төрийн өмчит ЕБС                                              | 189 | 178 |
| 631    | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА                      | 119 | 75  |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага                                  | 119 | 75  |
| 65     | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ                                           | 108 | 104 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                            | 7   | 5   |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)           | 28  | 27  |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 5   | 5   |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 28  | 23  |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                    | 31  | 35  |
| 650010 | Гэрээт ажилтан                                                | 2   | 2   |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ)                                   | 7   | 7   |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код  | Үзүүлэлт                                                 | ТЗ цэвэр дүн |
|------|----------------------------------------------------------|--------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 218,444.2    |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 218,444.2    |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 163,585.7    |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 8,217.4      |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,100.4      |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 11,066.7     |
| 2105 | Нормативт зардал                                         | 64,499.0     |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 11,216.6     |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 85.7         |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,007.9      |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 59,392.1     |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 54,858.5     |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 32,066.3     |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 22,792.2     |
| I    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 218,444.2    |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 218,444.2    |
| III  | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)                 | 50.2         |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 50.2         |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад

чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь эрхэм зорилгоо “Сумын тогтвортой хөгжлийг хангах, төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын болон өөрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдынхаа тогтвор суурьшилтай мэдлэг чадвараа дээшлүүлэхэд нь анхаарах иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүргэх чадвар бүхий ажлын баг байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төсөвт байгууллагуудын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, төсөв захирагч нарт дотоод аудитын тайланг хүргүүлсэн байна. Мөн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар дотоод хяналтыг гүйцэтгэсэн, аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс төсөвт байгууллагууд болон сумын үйл ажиллагаанд жил бүр хяналт, шалгалт, үнэлгээг хийж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,538,662.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,386.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,770.6 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 920,901.8 мянган төгрөгөөр буюу 26.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

| Хүснэгт 1                                         | /мянган төгрөг/    |                    |                  |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|------------------|
| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
| Б                                                 | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 257,717.7          | 379,043.0          | 121,325.3        |
| Авлага                                            | 212,964.5          | 211,204.7          | (1,759.8)        |
| Урьдчилгаа                                        | -                  | -                  | -                |
| Бараа материал                                    | 183,912.5          | 266,925.1          | 83,012.6         |
| Үндсэн хөрөнгө                                    | 2,765,459.4        | 3,483,783.1        | 718,323.7        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>3,420,054.1</b> | <b>4,340,955.9</b> | <b>920,901.8</b> |
| Өр төлбөр                                         | 31,558.0           | 49,529.0           | 17,971.0         |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 3,388,496.1        | 4,291,426.9        | 902,930.8        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>3,420,054.1</b> | <b>4,340,955.9</b> | <b>920,901.8</b> |

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 379,043.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 121,325.3 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 266,925.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 83,012.6 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,483,783.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 718,323.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант онд Сум хөгжүүлэх сангаас төсөл шалгаруулж, зээл олгоогүй, зээлийн эргэн төлөлтөөс 37,512.1 мянган төгрөгөөр, мөн жилийн эцэст агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлого 27,302.4 мянган төгрөгөөр төлөвлөгөө давж биелснээс шалтгаалан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 321,811.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 997,287.8 мянган төгрөг, нийт 1,069,704.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 38,855.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Тус онд Эрүүл мэндийн яамнаас санхүүждэг улсын төсвийн Сум дунд эмнэлэг орон нутгийн төсөвт шилжин, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжиж, сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг болсонтой холбоотойгоор дээрх данснууд материаллагаар өсжээ.

Үйл ажиллагааны орлого 2,976,472.8 мянган төгрөг буюу өмнөх оноос 450,258.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 2,538,662.6 мянган төгрөг буюу өмнөх оноос 296.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Үйл ажиллагааны орлогын өсөлтийн 77.8 хувийг, үйл ажиллагааны зардлын өсөлтийн 83.6 хувийг Сум дунд эмнэлгийн санхүүгийн тайлангийн орлого, зарлага тус тус эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,291,426.9 мянган төгрөг болж өмнөх оноос 902,901.8 мянган төгрөгөөр өссөн нь Сум дунд эмнэлгийн засгийн газрын хувь оролцоо мөн тайлант оны үр дүн өссөнөөс тус тус шалтгаалжээ.

Говь-Угтаал сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд 47,994.4 мянган төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг тайлагнасан нь туслах үйл ажиллагааны орлого бөгөөд өмнөх оноос 29,826.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Сум дунд эмнэлгийн ахмадын сан, мал хамгаалах сангийн туслах үйл ажиллагааны орлогын өсөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Говь-Угтаал сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 22 дугаар тогтоолоор тайлант онд 102,212.4 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 156,193.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 152.8 хувиар биелүүлсэн байна.

### *Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого*

*/мянган төгрөг/*

| Орлогын төрөл                                                              | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | зөрүү           | хувь         |
|----------------------------------------------------------------------------|------------------|------------------|-----------------|--------------|
| <b>Татварын орлого</b>                                                     |                  |                  |                 |              |
| Үйл ажиллагааны орлого                                                     | 20,000.0         | 25,137.9         | 5,137.9         | 125.7        |
| Хадгаламжийн хүүгийн орлого                                                | 27,100.0         | 43,520.2         | 16,420.2        | 160.6        |
| Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого                                        | 1,000.0          | 1,070.0          | 70.0            | 107.0        |
| Бууны албан татвар                                                         | 1,260.0          | 1,740.0          | 480.0           | 138.1        |
| Улсын тэмдэгтийн хураамж                                                   | 1,100.0          | 1,547.4          | 447.4           | 140.7        |
| Хог хаягдлын үйлчилгээ                                                     | 2,000.0          | 4,221.0          | 2,221.0         | 211.1        |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 27,302.4         | 54,604.8         | 27,302.4        | 200.0        |
| Газрын төлбөр                                                              | 17,100.0         | 18,690.1         | 1,590.1         | 109.3        |
| Малын тоо толгойн албан татвар                                             | -                | 84.0             | 84.0            |              |
| <b>Дүн</b>                                                                 | <b>96,862.4</b>  | <b>150,615.4</b> | <b>53,753.0</b> | <b>155.5</b> |
| <b>Татварын бус</b>                                                        |                  |                  |                 |              |
| Хүү торгууль                                                               | 5,000.0          | 4,778.5          | (221.5)         | 95.6         |
| Бусад орлого                                                               | 350.0            | 800.0            | 450.0           | 228.6        |
| <b>Дүн</b>                                                                 | <b>5,350.0</b>   | <b>5,578.5</b>   | <b>228.5</b>    | <b>104.3</b> |
| <b>Нийт дүн</b>                                                            | <b>102,212.4</b> | <b>156,193.9</b> | <b>53,981.5</b> | <b>152.8</b> |

*Эх сурвалж: Говь-Угтаал сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хадгаламжийн хүүгийн орлого 16,420.2 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 27,302.4 мянган төгрөгөөр давсан нь материаллаг дүнтэй байна.

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 2 дахин давж биелсэн нь жилийн эцэст Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эдлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгогдсонтой холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Говь-Угтаал сумын ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,296,399.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,296,399.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Говь-Угтаал сумын ИТХ-ын 2021 оны 19 болон 22 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 30,159.1 мянган төгрөгөөр өсгөн, 2,326,558.6 мянган төгрөгөөр баталсан байна. Санхүүжүүлэх эх үүсвэрт тусгай зориулалтын шилжүүлэг болон урьд оны үлдэгдлийг нэмж, эд хогшил, урсгал засварын зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,326,558.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,983,838.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 195,138.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 147,581.4 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,308,588.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 689,145.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36,228.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 292,596.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,294,144.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 668,307.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 17,310.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 87,436.4 мянган төгрөг, нийт 2,067,198.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 37,952.1 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 12,047.9 мянган төгрөгөөр тасалж, туслах үйл ажиллагааны орлого 37,466.4 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 14,466.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт бөгөөд тайлант онд шинээр нэмж зээл гаргаагүйтэй холбоотой төлөвлөгөө тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлогод төсөвт байгууллагуудын Ахмадын сан блон Мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлогыг тайлагнадаг байна. Тайлант онд Сум дундын эмнэлгийн санхүүгийн тайланг нэгтгэдэг болсонтой холбоотой тус байгууллагын Ахмадын сангийн орлогоор туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давж биелжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,980,554.5 мянган төгрөг буюу 85.1 хувьтай байгаа нь урсгал зардал 106,740.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 91,682.1 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийн гүйлгээ хийгдээгүйгээс 147,581.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 14,443.7 мянган төгрөгийг улсын төсөвт, 43,630.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 37,263.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 144,007.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37,174.1 мянган төгрөг, нийт 218,444.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 9,317.8 мянга, хангамж бараа материалын зардалд 11,066.7 мянга, нормативт зардал 64,499.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 11,216.6 мянга, томилолт зочны зардалд 85.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 8,007.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 59,392.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 54,858.5 нийт 195,652.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 22,792.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ**

Тайлант онд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м<sup>3</sup> тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь нэхэмжлэхийг нэмэгдүүлэн ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул хуучин гэрээний үнээр шилжүүлсэн байна.
2. Ерөнхий боловсролын сургуульд БСШУЯ-аас хэрэгжүүлж байгаа Багшийн хөгжил шавьд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан 4,299.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Хөтөлбөрийн дагуу бага ангийн 105 сурагчдад цахимаар хичээл хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1,963.0 мянган төгрөгөөр флаш худалдан авч тараасан, үлдсэн санхүүжилтийг “Багш хөгжлийн институтээс багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг авсан байна.

### **3.8 Аудитын ГОЛ АСУУДАЛ**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудаас сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд удирдлага зохион байгуулалтын хувьд доголдолтой, дотоод хяналт хангалтгүй аудитор өндөр шүүмжлэлтэй хандаж буй эрсдэлтэй асуудал нь урсгал засварын зардлаас бүрдэл дутуу анхан шатны баримтаар 9,892.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.

Харин төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэгдсэн тайланд аудитын гол асуудал нь сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 124,056.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 135,025.4 мянган төгрөг болгож баталж Засгийн



газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлигүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*/, 1.4 /*энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх*/ заасныг тус тус зөрчсөн асуудал байна.

### **3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь 2021 онд нийт 145,795.1 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулан мэдээлсэн.

#### **3.9.2 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн харилцааны дүрэм" зөрчсөн зөрчлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар, Тусгай зориулалтын сангууд, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 219,812.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 21,278.0 мянган төгрөгийн 5 алдааг



залруулж, 159.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 198,375.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

Завсрын аудитаар тогтоосон 159.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 198,375.1 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг холбогдох байгууллагууд албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 4,922.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 40,149.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 2 заалт зөвлөмж хүргүүлсэн ба бүрэн хэрэгжсэн байна.

*Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |          | Биелэгдээгүй |     | Хэрэгжилтийн хувь |
|-----------------|---------------------|----------|---------|----------|--------------|-----|-------------------|
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн      | Тоо          | Дүн | Хувь              |
| Төлбөрийн акт   | 4                   | 4,922.9  | 4       | 4,922.9  |              |     | 100.0             |
| Албан шаардлага | 5                   | 40,149.2 | 5       | 40,149.2 |              |     | 100.0             |
| Зөвлөмж         | 2                   | -        | 2       | -        |              |     | 100.0             |
| Нийт            | 11                  | 45,072.1 | 11      | 45,072.1 |              |     | 100.0             |

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 592,715.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 376,191.8 мянган төгрөгийн 14 алдааг аудитын явцад залруулж, 287.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 216,235.8 мянган төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 36.5 хувийг залруулагдаагүй, 63.5 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тусгай зориулалтын сангуудын тайланд хийсэн аудитаар нийт 134,780.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс

105.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 10,618.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 124,056.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 99.9 хувийг залруулагдаагүй, 0.1 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Нийт алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 356,929.4 мянга, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 322,833.4 мянга, арвилан хэмнэлттэй холбоотой 1,056.1 мянга, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 46,676.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөв захирагч нарын санхүүгийн тайланг нэгтгэхдээ 105.0 мянган төгрөгийн авлагыг илүү тайлагнасан;

#### 4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлан дахь 10,300.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Санхүүгийн тайлан дахь 318.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 124,056.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 135,025.4 мянган төгрөг болгож баталж Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т */үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлиггүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/* заасныг тус тус зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/<br>д                                                     | Байгууллагын нэр  | Нийт алдаа, зөрчлийн |           | Үүнээс    |           |               |       |                 |           |         |           |
|-------------------------------------------------------------|-------------------|----------------------|-----------|-----------|-----------|---------------|-------|-----------------|-----------|---------|-----------|
|                                                             |                   |                      |           | Залруулга |           | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |           | Зөвлөмж |           |
|                                                             |                   | Тоо                  | Дүн       | Тоо       | Дүн       | Тоо           | Дүн   | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн       |
| 1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд: |                   |                      |           |           |           |               |       |                 |           |         |           |
| 1                                                           | ЕБС               | 1                    | -         |           |           |               |       | 1               | -         |         |           |
| 2                                                           | Цэцэрлэг          | 1                    | -         |           |           |               |       |                 |           | 1       | -         |
| 3                                                           | ЗДТГ              | 2                    | 7,018.8   |           |           |               |       | 1               | 7,018.8   | 1       | -         |
| 4                                                           | ОНХС              | 1                    | 190,649.1 |           |           |               |       | 1               | 190,649.1 |         |           |
| 5                                                           | ТТЗ               | 1                    | 124,056.4 |           |           |               |       |                 |           | 1       | 124,056.4 |
| Дүн                                                         |                   | 6                    | 321,724.3 | -         | -         | -             | -     | 3               | 197,667.9 | 3       | 124,056.4 |
| 2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:                        |                   |                      |           |           |           |               |       |                 |           |         |           |
| 1                                                           | ЕБС               | 7                    | 351,747.3 | 3         | 350,510.9 | 1             | 159.8 | 3               | 1,076.6   |         |           |
| 2                                                           | Цэцэрлэг          | 3                    | 1,728.1   | 3         | 1,728.1   |               |       |                 |           |         |           |
| 3                                                           | Соёлын төв        | 1                    | 535.5     | 1         | 535.5     |               |       |                 |           |         |           |
| 4                                                           | ЭМТ               | 3                    | 955.5     | 1         | 780.1     | 1             | 128.0 | 1               | 47.4      |         |           |
| 5                                                           | ЗДТГ              | 7                    | 32,785.1  | 5         | 21,991.2  |               |       | 2               | 10,793.9  |         |           |
| 6                                                           | ИТХ               | 1                    | 646.0     | 1         | 646.0     |               |       |                 |           |         |           |
| 7                                                           | ОНХС              | 1                    | 6,650.0   |           |           |               |       | 1               | 6,650.0   |         |           |
| 8                                                           | ТЗС               | 2                    | 10,618.7  |           |           |               |       | 2               | 10,618.7  |         |           |
| 9                                                           | ТТЗ               | 1                    | 105.0     | 1         | 105.0     |               |       |                 |           |         |           |
| Дүн                                                         |                   | 26                   | 405,771.2 | 15        | 376,296.8 | 2             | 287.8 | 9               | 29,186.6  | -       |           |
|                                                             | Нийт зөрчлийн дүн | 32                   | 727,495.5 | 15        | 376,296.8 | 2             | 287.8 | 12              | 226,854.5 | 3       | 124,056.4 |

